



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЛУВСАНЖАМЦ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.24 № ХХГ/948
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх
тухай

Танаас 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 11 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 26 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265003478



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 03 дугаар сарын 24-ны
өдрийн 121/948 тоот албан
бичгийн 1 дүгээр хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦААС “НОГООН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АВАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ 57 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

/2025 оны жилийн эцсийн байдлаарх мэдээлэл/

Асуулга 1.Тогтоолд тусгасан Засгийн газрын хэрэгжүүлэх 17 арга хэмжээнээс өнөөдрийн байдлаар бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд байгаа болон бодит ахиц гараагүй арга хэмжээнүүдийг ялган тодорхойлж, арга хэмжээ тус бүрийг “хариуцсан байгууллага, хэрэгжилтийн үе шат, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулсан төсөв, бодит үр дүн” гэсэн агуулга бүхий нэгдсэн хүснэгт, тайлбар мэдээллийн хүрээнд:

“Тушаал шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/700 дугаар тушаалын хавсралтаар “Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийн төсөл арга хэмжээний зардлаас Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэхээр 700,0 сая төгрөгийг тусган баталсан бөгөөд “Хөрөнгө гаргах тухай” тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/329 дүгээр тушаалаар Төрийн банк болон Хас банканд гэрээний үндсэн дээр тус бүр 300.0 сая, нийт 600.0 сая төгрөгийн хүүгийн татаас олгохоор шийдвэрлэж, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Сангийн яаманд санхүүжилттэй холбоотой хүсэлтийг хүргүүлсэн. Тогтоолд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг 2 дугаар хавсралтад хавсаргав.

Асуулга 2.Тогтоолд заасны дагуу ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ногоон зээлийн зохицуулалт, ногоон барилгын шалгуур, эрчим хүчний хэмнэлтийн стандарт, “Хэмжих-Хянах-Тайлагнах” тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газраас тодорхой хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулах үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомж болон салбарын яамдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн тогтоолууд, батлагдсан эсэх, хэрэгжилтийн явцын талаарх бодит мэдээлэл, мөн боловсруулалтын шатанд байгаа эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдээлэл, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн бодит хугацаа, уг баримт бичгүүд бодлогын хувьд ямар өөрчлөлт, үр нөлөө үзүүлэхээр тооцоолсон талаарх төлөвлөгөө бүхий тайлан, мэдээллийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэн амьдран суух зориулалтаар ногоон орон сууц худалдан авах, барихад, мөн гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авахад 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлт эдлүүлэхээр “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг дараах агуулгыг тусгасан.
Үүнд:

23.3.Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцны нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдох дараах зардалтай тэнцэх хэмжээний орлогод ногдох 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлтийг тухайн татвар төлөгчид нэг удаа эдлүүлнэ:

23.3.1.эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт хангасан орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө;

23.3.2.гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авсан зардал зэрэг болно.

Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд үндэслэн дасан зохицох арга хэмжээг төлөвлөх, шаардагдах санхүүжилтийг олон талын эх үүсвэрээс шийдвэрлэх, ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн олон улсын механизмуудыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилготой анхдагч хуулийн төслийг Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран боловсруулж байна. Энэхүү "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай" анхдагч хуулийн төсөлд ногоон санхүүжилтийн эх үүсвэр, ногоон санхүүжилтийн хэрэгсэл, хөшүүрэг, санхүүжилтийн ил тод байдал зэрэг тогтолцоотой холбоотой зохицуулалтыг тусгаад байна.

Асуулга 3.Ногоон санхүүжилтийг бодит эдийн засгийн механизм болгон хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хамрагдсан банк, санхүүгийн байгууллагуудын талаар, мөн ногоон зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд, тэдний хамаарах салбар, бүс нутгийн байршил, олгогдсон зээлийн нийт хэмжээ, түүнчлэн ногоон зээлийн хүүгийн бодлого бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж, дундаж хүү өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн, улсын төсвөөс хүүгийн татаас, дэмжлэг хэлбэрээр хэдий хэмжээний санхүүжилт олгосон, 2026 онд олгох зээлийн талаар бодит тоон үзүүлэлт бүхий нэгдсэн мэдээллийн хүрээнд:

Тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас агаар орчны бохирдлыг бууруулах дулаалга, ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүтээгдэхүүний санхүүжилтийг дэмжих зорилгоор "Тушаал шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/700 дугаар тушаалын хавсралтаар "Ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний жагсаалт, зээлийн хүүгийн хувь хэмжээ"-г баталж, иргэнд 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 6 хувь, аж ахуйн нэгж байгууллагад 15 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 8 хувийн хөнгөлөлт олгох ажлыг Төрийн банк, Хаан банк, Хас банктай хамтран хэрэгжүүлэх, нийт 600.0 сая төгрөгийг хүүгийн хөнгөлөлтөд зарцуулахаар гэрээ байгуулаад байна.

Асуулга 4.Эрчим хүчний хэмнэлт, дулаалгын бодлогоор хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хамрагдсан нийт өрхийн тоо, энэ нь жилд хичнээн Гкал дулаан, МВт.ц цахилгаан хэмнэж байгаа, үүний үр дүнд агаарын бохирдлын түвшинд бодитоор өөрчлөлт гарсан талаарх тоон үзүүлэлт, тооцоолол бүхий судалгаанд тулгуурласан мэдээлэл байгаа эсэх талаар:

Эрчим хүчний хэмнэлт, дулаалгын бодлогын хүрээнд нийтийн орон сууцны дулаалгыг дэмжих зорилгоор 2022 оноос Европын холбооны "Nema Facility" байгууллагын 18.0 сая евро болон Барилга, хот байгуулалтын яам (хуучин нэрээр)-ны 8.0 сая евро, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 6.5 сая еврогийн санхүүжилтээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GIZ)-ын хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хариуцан хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний яам уг төслийн хэрэгжилтийн шатанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр оролцож байна. Мөн барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлт, дулаалгын бодлогын хүрээнд Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ыг шинэчлэхэд холбогдох арга хэмжээг нэмж тусгуулан батлуулаад байна.

Дулаалга хийгдэж байгаа орон сууцны бүх барилгад дулааны тоолуур суурилуулснаар хэмнэж буй дулааныг тооцоолох нөхцөл бүрдсэн. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/257, А/252 дугаартай тушаалаар баталсан "Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам"-ын хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 855 барилгын зураг, төсөл орон тооны бус экспертүүдээр хянагдаж, эрчим хүчний гэрчилгээ олгогдсон байна.

Агаарын бохирдлын түвшинд бодитоор өөрчлөлт гарсан талаарх тоон үзүүлэлт, тооцоолол бүхий судалгаанд тулгуурласан мэдээллийг гаргах зорилгоор "Хүлэмжийн хийн тооллогын цахим систем"-ийг хөгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд "Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох цахим систем"-ийн 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах 5 дүүргийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ 2024 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

- 1.Хан-Уул дүүрэгт 3,38 хувиар;
- 2.Баянзүрх дүүрэгт 0,5 хувь;
- 3.Баянгол дүүрэгт 2,74 хувь;
- 4.Сүхбаатар дүүрэгт 3,1 хувь;
- 5.Чингэлтэй дүүрэгт 0,92 хувиар тус тус өссөн.

Харин Сонгинохайрхан дүүрэг 1,26 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Хүлэмжийн хийн ялгарал нь тухайн дүүргийн хүн амын тоо, орон сууц, олон нийтийн барилгын тооноос хамаарч ялгаатай тооцоологдож байна. Цаашид тооллогын системийг улам хөгжүүлж инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдоогүй барилга байгууламжийг бүртгэх, хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох аргачлалыг батлуулах ажлууд үе шаттайгаар хийгдэж байна.

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон нийт 1013 блок барилга буюу 181.2 Гкал/ц дулааны ачаалалтай барилгыг 100 хувь дулаалах урьдчилсан тооцоог хийсэн. Дээрх барилгуудыг бүрэн дулаалснаар төвлөрсөн дулаан хангамжийн системийн ачааллыг бууруулах, улмаар дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэх боломжтой гэж тооцоолж байна.

Урьдчилсан тооцоогоор барилгуудыг дулаалснаар нийт 61.1 гкал/ц (Амгалан дулааны станц-16.6 гкал/ц, дулаан цахилгаан станц 2-ын сүлжээ-1.9 гкал/ц, дулааны цахилгаан станц 3-ын сүлжээ 5.0 гкал/ц, дулаан цахилгаан станц 4-ийн сүлжээ -37.6 гкал/ц) дулааны ачаалал буурах боломжтой бөгөөд уг тооцооллыг дулааны эх үүсвэрийн сүлжээгээр тооцоолсон болно.

Одоогийн нөхцөл байдалтай харьцуулахад нэг барилгаас 40 хүртэлх хувийн дулааны хэмнэлт бий болгох зорилгоор зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж, уг даалгаврын дагуу нэг маягийн зураг төсөл боловсруулсан бөгөөд төслийн хүрээнд 2025 онд 45 блок барилгад дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дулааны хэмнэлт бий болгоход дараах 2 үзүүлэлт маш чухал нөлөө үзүүлдэг. Үүнд:

- 1.Халаалтын системд ямар нэг өөрчлөлт хийж, хэмнэлтээ барьж үлдэх оролдлого хийгээгүй бөгөөд үнэ тариф задгай байгаа тул улаан алдагдлаа бууруулсан ч үнэлэгдэхгүй бүрэн тооцоологдох боломжгүй байх;

2.Ханган нийлүүлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх техникийн боломж алдагдаж, дутуу нийлүүлэлтэй байх.

Мөн дулаалгын үр дүнд бий болох дулааны хэмнэлтийг хэмжих, хэрэглээний дата мэдээллийг нарийвчлан бүртгэх зорилгоор 2024 онд Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийт 298 угсармал барилгад дулааны тоолуур суурилуулсан.

“Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 04, 05, 06 дугаар тогтоол, “Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2025 оны А/651, А/983 дугаар тушаал, захирамжуудын хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг дулаалж, хийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 3950 өрхийг бүрэн дулаалж, 3976 өрхөд хийн түлшний төхөөрөмж суурилуулсан бөгөөд дулаалга хийснээр цахилгааны хэрэглээ 2 дахин буурч, зардал багассан.

Асуулга 5.Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын түвшинд нэгдсэн зохицуулалтын бүтэц, тухайлбал ажлын хэсэг, зөвлөл, дэд хороо зэргийг байгуулж ажилласан эсэх, бодлогын уялдаа холбоог төвлөрсөн байдлаар хариуцаж ирсэн ямар байгууллага байгаа талаарх тодорхой мэдээлэл, хэрэгжилтийн явцад тулгарсан эрх зүйн зохицуулалтын саад, санхүүжилтийн хүндрэл, институц хоорондын давхардал, уялдаа холбоо сул зэрэг бодит бэрхшээлүүдийн талаар Засгийн газрын зүгээс хийсэн үнэлгээ, дүгнэлтийн хүрээнд:

Засгийн газрын хэрэгжүүлэхээр тогтоосон 1 заалтын хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын аргачлалын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж үнэлж, биелэлтийг Улсын Их Хуралд хүргүүлсэн. Энэхүү үнэлгээгээр тогтоолын хэрэгжилт 50 хувийн биелэлттэй буюу, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Асуулга 6.Цаашид 2026-2028 онд ногоон санхүүжилтийн тогтолцоог эдийн засгийн салбарын бодит механизм болгох, иргэн, аж ахуйн нэгжид бодитоор хүртээмжтэй болгох, хотын агаарын бохирдол, эрчим хүчний хэрэглээнд хэмжигдэхүйц нөлөө үзүүлэх чиглэлээр Засгийн газраас баримтлах төлөвлөгөө, зорилт, шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны бодлогын талаар:

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын алба хамтран нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлийн 5 зорилт 47 арга хэмжээ бүхий 2026-2030 он хүртэлх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг шалгуур үзүүлэлтийг хамт боловсруулсан. Уг төлөвлөгөөний төслийг Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд төсөл дэмжигдвэл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, эцэслэн батлах болно.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 06 дугаар сарын 06-ны
өдрийн 117/048 тоот албан
бичгийн 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН
57 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

/2025 оны жилийн эцсийн байдлаар, тогтоолын хэрэгжилтийн мэдээллийг шинэчлэх ажил хийгдэж байна/

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Бодит үр дүн	Хариуцсан байгууллага	Хэрэгжилтийн үе шат
Нэг. "Хот, суурин газрыг орон сууцжуулахад ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэл"-ээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай:				
1.1.	1/ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор урт хугацаатай, хүүгийн татаастай санхүүгийн зохицуулалтын тогтолцоог бий болгож, холбогдох хууль тогтоомжид тусгах талаар зохих арга хэмжээг авч, хэрэгжилтийг зохион байгуулах;	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний 3.10.1.5-д заасан арга хэмжээний дагуу 2026 оны улсын төсвийн төсөлд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ногоон зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 800 сая төгрөг төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн барьсан. Мөн тус яамнаас уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд үндэслэн дасан зохицох арга хэмжээг төлөвлөх, шаардагдах санхүүжилтийг олон талын эх үүсвэрээс шийдвэрлэх, ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн олон улсын механизмуудыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр анхдагч хуулийн төслийг Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран боловсруулж байна. Энэхүү "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай" анхдагч хуулийн төсөлд ногоон санхүүжилтийн эх үүсвэр, ногоон санхүүжилтийн хэрэгсэл, хөшүүрэг, санхүүжилтийн ил тод байдал зэрэг тогтолцоотой холбоотой зохицуулалтыг тусгаад байна.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/6065 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд
	2/ногоон зээлийн хүүгийн татаасын 80-аас доошгүй хувийг дулаалгын материал, угааргүй халаалтын тоног төхөөрөмжид төвлөрүүлэх зорилгоор агаар орчны бохирдлыг бууруулах	2025 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд /БОУАӨС/-ын багцын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас агаар орчны бохирдлыг бууруулах дулаалга, ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүтээгдэхүүний санхүүжилтийг дэмжиж "Ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний жагсаалт, зээлийн хүүгийн хувь хэмжээ"-г "Тушаал		

1.2.	дулаалта, ногоон барилта, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүтээгдэхүүний санхүүжилтэд чиглүүлсэн агуулгаар "Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээ"-г шинэчлэн боловсруулж, уг гэрээг жил бүрийн эхний улиралд багтаан арилжааны банкуудтай байгуулж, хэрэгжүүлэх;	шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/700 дугаар тушаалын хавсралтаар баталж, иргэнд 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 6 хувь, аж ахуйн нэгж байгууллагад 15 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилийн 8 хувийн хөнгөлөлттэйгөөр Төрийн банк, Хаан банк, Хас банктэй хамтран хэрэгжүүлэхээр баталсан. Энэ хүрээнд нийт 600 сая төгрөгийг хүүгийн хөнгөлөлтөд зарцуулахаар Төрийн банк болон Хас банктэй гэрээ байгуулаад байна. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын дээрх тушаалын хавсралтаар агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн төсөл арга хэмжээний зардлаас Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэхээр 700 сая төгрөг батлагдсан бөгөөд "Хөрөнгө гаргах тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарын бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/329 дүгээр тушаалаар Төрийн банк болон Хас банканд гэрээний үндсэн дээр тус бүр 300 сая, нийт 600 сая төгрөгийн хүүгийн татаас олгохоор шийдвэрлэж, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Сангийн яаманд санхүүжилттэй холбоотой хүсэлтийг хүргүүлсэн.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/6065 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд
1.3.	3/ногоон зээл, хүүгийн татаасын ил тод байдлыг хангах "Хэмжих-Хянах-Тайлагнах" баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бий болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар зохих арга хэмжээг авч, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;	"Ногоон зээлийн бүтээгдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/185 дугаар тушаалаар ногоон зээлийн бүтээгдэхүүний жагсаалтыг шинэчлэн, 29 нэр төрлийн бүтээгдэхүүнд олгохоор шийдвэрлэсэн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс /СТБЗ/ 2023 онд "Тогтвортой хөгжлийн зорилтуудын /ТХЗ/ санхүүгийн таксономи"-ийг баталж, уг таксономийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл туршилтын журмаар нэвтрүүлэн, хэрэгжилтийн явцад шаардлагатай сайжруулалтыг хийхээр тусгасан. Банкууд болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо /ТоС холбоо/-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу туршилтын хугацааг 2026 оны 1 дүгээр улирал хүртэл сунгасан бөгөөд Монголбанк нь ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг шинэчлэх чиглэлээр ТоС холбоо, банкууд болон холбогдох яамнуудтай хамтран ажиллаж байна. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түжрэл, агаарын бохирдол, хүн амын хэт төвлөрлийг сааруулах зорилгоор улсын зэрэглэлтэй 14 хот, дагуул 3 хот байгуулахаар "Хот байгуулалтын тухай" хуульд тусгасан. 2025-2032 онд 820,3 га талбайд 6 дэд төв, гэр хорооллын 4,384 нэгж талбарыг дахин төлөвлөн барилгажуулахаар нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/6065 дугаартай албан бичиг/ Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд
		Нийслэлийн Засаг даргын тамгын газар		

1.4.	<p>4/уугаагүй бүсэд хамаарах дэд төвүүд, агаарын бохирдол өндөртэй болон дахин төлөвлөлтийн бүсийг тогтоож, нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган, тухайн бүсэд эрчим хүчээр найдвартай хангах төлөвлөлтийг боловсруулж, ипотекийн болон ногоон зээлийн хөнгөлөлт, ногоон зээлийн хүүгийн татаасын бодлогыг чиглүүлэх, энэ талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх;</p>	<p>2025 оны 3 улирлын байдлаар Сэлбэ, Баянхошуу дэд төвийн инженерийн дэд бүтцийг 100 хувь гүйцэтгэж, орон сууцны барилгын ажлыг эхлүүлсэн. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 177 блок, 20247 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулсан. "Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2025 оны А/651/983 дугаар тушаал, захирамжаар бүх төрлийн хий, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрт үе шаттайгаар холбох ногоон бүсийг тогтоосон.</p> <p>"Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2025 оны А/651/983 дугаар тушаал, захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, тус бүсэд мөрдөх журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт харууцуулан ажиглаж байна. Аймаг, орон нутагт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон тухайн аймгийн Засаг даргын хамтарсан тушаал захирамжаар Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Хэнтий, Төв, Хөвсгөл аймгууд агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг батлан мөрдөж байна.</p>	<p>/2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03/7454 дугаартай албан бичиг/</p> <p>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/6065 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>	
1.5.	<p>5/эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шалгуур /BestGER/-т суурилсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, аудит, хяналт шинжилгээ, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>"Банкны ногоон зээлийн тайлангийн маягт батлах тухай" Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А-198 дугаар тушаалын дагуу Монголбанк нь банкуудын ногоон зээлийн тайланг улирал тутам нэгтгэн боловсруулж, олон нийтэд тогтмол танилцуулж байна. Түүнчлэн, 2022 оноос эхлэн банкуудын ногоон зээлийн тайлангийн гол үзүүлэлтүүдийг хүйсээр ангилан жил бүр оны эцсийн байдлаар нэгтгэн нийтэлж байна.</p> <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас боловсруулж байгаа "Барилгын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д "ногоон барилга", "ногоон байгууламж" гэсэн нэр томъёоны тодорхойлолт, "ногоон барилга, түүний төлөвлөлт" гэсэн зүйл нэмэлтээр оруулж холбогдох зохицуулалтыг тусгасан. Уг хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлсэн.</p>	<p>Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/</p> <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>	

<p>1.6.</p>	<p>б/хот, суурин газрын гэр хорооллын хэсэгт амины орон сууц барьсан тохиолдолд 50-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотлох тохирлын болон ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээг тус тус авсныг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгох талаар эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;</p>	<p>Арилжааны банк /Хас, Голомт, Капитрон, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк/-ны холбогдох албан тушаалуудтай 2024 оны 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Амины орон сууцны ипотекийн зээл олгоход тулгамдаж буй асуудлын талаар санал авахаар уулзалт зохион байгуулсан. Ипотекийн зээлийн санхүүжилтэд Амины орон сууцыг хамруулах үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор Монголбанктai хамтран ажиллаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын 1.2.13 дахь заалтад 2024 оны 10 дугаар 09-ний өдөр өөрчлөлт оруулж, "Амины орон сууц" гэх нэр томъёоны ойлголтыг нарийвчлан тодорхойлсон. Амины орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч арилжааны банкнуудад журмын өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг үнэлэх үнэлгээний систем /BestGer/, тавигдах шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх уулзалтыг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Монголбанктai хамтран зохион байгуулсан. Амины орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг ямар аргачлалаар олгох талаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр "Монголын банкны холбоо" ГҮТББ-ийн Зээлийн эрсдэлийн хороогоор хэлэлцүүлж, "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г батлуулах, Ногоон барилгын аудитор бэлтгэсний дараа дахин хэлэлцэхээр тохиролцсон. Ногоон барилгын аудитор бэлтгэх сургалтыг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж сургалт, шалгалтад тэнцэж, шаардлага хангасан 18 аудитор гэрчилгээ олгосон. Мөн 2025 оны 10 дугаар сард зохион байгуулсан сургалт, шалгалтад тэнцэж шаардлага хангасан 11 аудитор гэрчилгээ олгох тухай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын 2025 оны 11 дүгээр 20-ны өдрийн А/158 дугаар тушаал гарсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-235 дугаар тушаалаар баталсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын 1.2.13 дугаар заалтыг "Амины орон сууц" гэж аймаг, нийслэл, сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, орон сууцны бүх хэсэг нь бие даасан ханаар хүрээлэгдсэн, эсвэл тусгаарлах хана нь нийлсэн болон хагас нийлсэн, эгнээгээр баригдсан орон сууцны зориулалттай сууцыг" гэж өөрчлөн баталсан. Мөн журмын 2.6.4 дэх заалтад Амины орон сууцны хувьд дэд бүтэц /цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга/-ийн шийдэл бүхий эрх бүхий байгууллагын шийдвэрээр байнгын ашиглалтад шинээр оруулсан, эсхүл барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын</p>	<p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p>	<p>Хэрэгжих шатанд</p>
			Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр цахимаар/	

		<p>шийдвэрээр ашиглахыг хориглоогүй ашиглалтад байгаа орон сууц байхаар заасан. Ингэснээр эрчим хүчний хэмнэлттэй, дэд бүтэц бүхий, тусгаарлах хана нь нийлсэн, хагас нийлсэн хоёр болон түүнээс дээш тооны эгнээгээр баригдсан амины орон сууц худалдан авах өрх хөтөлбөрийн зээлд хамрагдах боломж бүрсэн. Түүнчлэн, амины орон сууцанд олгосон ипотекийн зээлийн хэмжээ 2025 оны 11 дүгээр сарын байдлаар өмнөх оноос 39.5 хувиар өсөж, 153.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс хөнгөлөлттэй орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 2.9 тэрбум төгрөгийн зээл олгосон.</p>		
1.7.	<p>7/төрийн өмчит болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг төлөвлөхдөө ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээний "В" болон түүнээс дээш үнэлгээтэй, 50-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэй байх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>"Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНБД 31-25-22/ барилгын норм, дүрэм, Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/ барилгын норм, дүрмийг тус тус 2022 онд шинэчлэн боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төрийн өмчит болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийн төлөвлөлтийн 512 төсөл арга хэмжээний ажлын зураг төсөл, төслийг баталгаажуулж, эрчим хүчний хэмнэлтийн "С" болон түүнээс дээш гэрчилгээ олгосон. /2025 оны эхний хагас жилийн байдлаар/ Үүнд сургууль 25, цэцэрлэг 18, эмнэлэг 15, дотуур байр 8 тус тус байна.</p>	<p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p>	<p>Хэрэгжих шатанд</p>
		<p>Ногоон барилгын шаардлага болон Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Эмнэлгийн барилгын шинэчилсэн норм дүрмийг баримтлан боловсруулсан зураг төслөөр 2021 онд нийт 7 эмнэлгийн барилга байнгын ашиглалтад оруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон аймаг, Баян-Өндөр сум/; - Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Хэнтий аймаг, Хэрлэн сум/; - Эрүүл мэндийн төвийн барилга /Хэнтий аймаг, Хэрлэн сум, Өлзийт тосгон/; - Эрүүл мэндийн төвийн барилга /Баян-Өлгий аймаг, Ногооннуур сум/; - Эрүүл мэндийн төвийн барилга /Баян-Өлгий аймаг, Улаанхус сум/; - Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул аймгийн, Орхон сум/; 	<p>Эрүүл мэндийн яам /2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 06/5496 дугаартай албан бичиг/</p>	

1.8.	<p>8/төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй технологид үе шаттайгаар шилжүүлэх;</p>	<p>- Эрүүл мэндийн төвийн барилга / Архангай аймаг, Хайрхан сум/. Мөн Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр 2022 онд Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд ногоон технологи бүхий Өрхийн эрүүл мэндийн төв байгуулсан.</p> <p>Хүлэмжийн хий ялгаруулалтыг бууруулах амлалт үүргийнхээ хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2025 оны 91 дүгээр тогтоолоор "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ыг шинэчлэн баталсан. Үндэсний хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг /суурь нөхцөл/ хамгийн их ялгаруулагч зургаан тэргүүлэгч эдийн засгийн салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгасан арга хэмжээнд үндэслэн тооцоолж үзэхэд 2010 онд 25.8 сая тонн CO₂-эква. хэмжээтэй байсан бол 2035 онд 81.7 сая тонн CO₂-эква. болж 3.2 дахин өсөх төлөвтэй байна. Иймд 2035 он гэхэд үндэсний хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилтыг салбарын түвшинд тодорхойлсон. Барилгын салбарт 2030 он гэхэд 633.5 мян.тн CO₂-эква, 2035 он гэхэд 1,066.1 мян.тн CO₂-эква бууруулах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ногоон орон сууцны барилга /АХБ/-2030 он гэхэд 102.3 мян.тн, 2035 он гэхэд 126.4 мян.тн; - Эрчим хүчний хэмнэлттэй амины шинэ орон сууц-2030 он гэхэд 57.0 мян.тн, 2035 он гэхэд 98.0 мян.тн; - Сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн шинэчлэл, засвар-2030 он гэхэд 68.8 мян.тн, 2035 он гэхэд 131.2 мян.тн; - Төсөвт байгууллагын барилгын дулаан техникийн шинэчлэл-2030 он гэхэд 104.6 мян.тн, 2035 он гэхэд 197.2 мян.тн. <p>Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагуудын харьяанд нийт 4083 барилга байгууламж ашиглагдаж байгаа ба улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд шинээр барьж байгаа сургууль, цэцэрлэгийн барилгыг стандартын дагуу эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй технологи буюу төвлөрсөн гадна шугам сүлжээний системд холбож барих, одоо үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй болгох боломжийг судлах, эрчим хүчний тэгш хүртээмжтэй шилжилт төслийн хүрээнд эрчим хүчний шилжилтийн замын зураг боловсруулахаар төрийн өмчийн нийт 11 сургууль, цэцэрлэгийн барилгыг сонгон хүлэмжийн хийн ялгарлыг тооцох судалгааны ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Монгол</p>	<p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p> <p>Боловсролын яам /2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 02/6296 дугаартай албан бичиг/</p>	Хэрэгжих шатанд
------	--	--	---	-----------------

		<p>Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар боловсролын салбарт боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж барих 180 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын /хуучнаар/ 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 211 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт, норм дүрэм, 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 193 дугаар тушаалаар батлагдсан сургуулийн өмнөх боловсролын барилгын норм дүрмийн дагуу утаагүй технологийг ашигласан, гадна инженерийн дэд бүтэцтэйгээр баригдаж байгаа бөгөөд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар шинээр хэрэгжих 39 барилга байгууламжийн төсөл арга хэмжээ нь эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй технологи ашигласан барилга баригдахаар төлөвлөгдсөн.</p> <p>2024 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулж, судалгаанд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын 246 зуух тоологдсоноос 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 37 зуух нь хийн халаалт болон цахилгаанд бүрэн шилжсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/1052 дугаар захирамжаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд дулаан, эрчим хүч үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагад түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар зогсоож, технологийг шинэчилж, угааж баяжуулсан нүүрс /мидлинг/-ний хэрэглээнд бүрэн шилжсэн.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03/7454 дугаартай албан бичиг/</p>	
1.9.	<p>9/монгол гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын стандартыг шинээр боловсруулж, үйлдвэрлэл, аудит, хяналт шинжилгээ, баталгаажуулалтын тогтолцоог бий болгож, холбогдох хууль тогтоомжид тусгах талаар зохих арга хэмжээг авч, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Үндэсний стандартын төслийг сонирхогч талууд зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулж, стандартчилал техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталдаг. Монгол гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын стандартыг шинээр боловсруулах саналын төсөл одоогоор ирүүлээгүй байна.</p> <p>"Ногоон барилгын хүрээлэн" ТББ-аас Дөрхан, Эрдэнэт, Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженер, техникийн ажилчид болон аж ахуйн нэгж, байгууллагуудад "Ногоон барилгын үнэлгээ/BestGER/-ний аргачлал", "Ногоон барилгын/BestGER/ гэрчилгээ олгох журам"-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулсан;</p>	<p>Стандарт хэмжил зүйн газар /2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 03/1196 дугаартай албан бичиг/</p> <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p>	Хэрэгжих шатанд

<p>1.10.</p>	<p>10) Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээлийн багцын 50-аас доошгүй хувийг ногоон барилга, барилгын материал үйлдвэрлэгч, эрчим хүчний хэмнэлт бий болгох чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч, ногоон барилгын баталгаажуулалт хийх иргэн, аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулах;</p>	<p>Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбар нь хурдан хугацаанд ажлын байр бий болгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, улмаар үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулдаг ба ихэнх улс орнууд тус салбарыг санхүүгийн болон санхүүгийн бус арга хэрэгслээр дамжуулан дэмжин хөгжүүлж байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2025 онд зээлийн эргэн төлөлт, төсвийн ерөнхийлөн захирагчийн багц, орон нутгийн эх үүсвэрээр 57.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 174 тэрбум төгрөгийн 1210 төсөл хүлээн авч, 56.5 тэрбум төгрөгийг 365 төсөлд хөнгөлөлттэй зээл олгохоор хороо, дэд хороо шийдвэрээр байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл буюу агро ойн аж ахуй, жимс, жимсгэнийн аж ахуйг дэмжих чиглэлээр 475 сая төгрөгийн зээлийг 4 төсөлд олгосон. Эдгээр төслийг хэрэгжүүлснээр 14 ажлын байр шинээр бий болж, 23 ажлыг байр хадгалагдана. Мөн ЖАЙКА-ийн "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төслөөс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 17.0 тэрбум төгрөгийг 45 төсөлд олгож, 367 ажлын байрыг нэмэгдүүлж, 335 ажлын байрыг хадгалсан үр дүнтэй байна.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар Хаан, Төрийн банкны Архангай аймаг дах салбаруудад олгосон Эко тээврийн хэрэгслийн зээл, Малчны ногоон зээл, Орчны бүсийн байгальд ээлтэй малчны зээл, гэр бүлийн ногоон зээл, Хэрэглээний ногоон зээл, Бизнесийн ногоон зээл, Тогтвортой ноос ноолуурын нийлүүлэлтийг дэмжих ногоон зээл, Хөдөө аж ахуйн тогтвортой, үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл /газар тариалан/, Ногоон эдийн засгийг дэмжих Монгефф зээл зэрэг ногоон зээлүүдэд 3,833,902,021.61 төгрөг зарцуулсан.</p> <p>"Банкны тухай" хуульд заасны дагуу Говь-Алтай аймгийн Хаан банкнаас "Банк тодорхой хэдэн эрх бүхий этгээдэд харилцагч болон банкны мэдээллийг гаргаж өгөхөөр зохицуулсан тул тус мэдээллийг гаргаж өгөх боломжгүй" гэсэн хариу тайлбар ирүүлсэн байна.</p> <p>Ховд аймгийн Төрийн банк Ховд салбарын хувьд 2024 онд 43 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 2 тэрбум төгрөгийн, 2025 онд 33 бизнес эрхлэгч эмэгтэйд 1.7 тэрбум төгрөгийн, нийт 76 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 3.7 тэрбум төгрөгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл олгож, эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаа, амьжиргааг дэмжиж ажилласан байна. Мөн 2025 онд 1 иргэнд 9 сая төгрөгийн Ногоон хэрэглээний зээл буюу Ахуйн хэрэглээний ногоон зээл олгосон</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрийн газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1517 дугаартай албан бичиг/</p> <p>Архангай аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 03/1554 дугаартай албан бичиг/</p> <p>Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/1594 дугаартай албан бичиг/</p> <p>Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар/</p>	<p>Хэрэгжсэн</p>
--------------	---	---	--	------------------

		<p>байна. 2025 онд 1 иргэнд 100 сая төгрөгийн Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл олгосон. 2024 онд 6 малчинд 150 сая төгрөгийн, 2025 онд 22 малчинд 470 сая төгрөгийн, нийт 28 малчинд 620 сая төгрөгийн Тогтвортой хөдөө аж ахуйн зээл буюу Малчны ногоон зээлийг тус тус олгосон байна.</p>	
<p>1.11.</p>	<p>11/ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээ, 70-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотлох тохирлын гэрчилгээтэй дулаалгын ажил гүйцэтгэсэн иргэнд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэн амьдран суух зориулалтаар ногоон орон сууц худалдан авах, барихад мөн гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авахад 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхээр "Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p>	<p>Сангийн яам /2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 03/1650 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>
<p>1.12.</p>	<p>12/ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээний "B" болон түүнээс дээш үнэлгээтэй, 70-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотолсон тохирлын гэрчилгээтэй амины орон сууцыг худалдсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварын хувь хэмжээг 1 хувь болгон бууруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэн амьдран суух зориулалтаар ногоон орон сууц худалдан авах, барихад мөн гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авахад 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p>	<p>Сангийн яам /2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 03/1650 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>
	<p>13/улсын хэмжээнд утааг бууруулах чиглэлээр дулаалгын төлөвлөгөөг боловсруулж, шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүргийн нийт 3950 өрхийн байшин болон гэр сууцыг дулаалах ажлыг нийслэлийн Засаг даргын А/1038 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан "Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээ"-ний зардлаас нийт 15,268,664,651 төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэж байна. Дээрх дүүргүүд сууц дулаалгын ажлыг бүрэн харууцаж төлөвлөгөө</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>

1.13.	<p>боловруулан байшин сууцтай өрхийн дэвээр, ханын дулаалгыг тендер шалгаруулалтаар, гэр сууцтай өрхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран чип дулаалгын багцаар тус тус дулаалж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар нийт 2476 гэр болон байшин сууц дулаалаад байна.</p> <p>"Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 04, 05, 06 дугаар тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон нийслэлийн Засаг даргын 2025 оны А/651, А/983 дугаар тушаал, захирамжуудын хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг дулаалж, хийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 3950 өрхийг бүрэн дулаалж, 3976 өрхөд хийн түлшний төхөөрөмжийг суурилуулаад байна. Дулаалга хийснээр хэрэглээ 2 дахин буурч, зардал багасаж байна.</p> <p>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран 2025 онд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийг гэр цэцэрлэгүүд болон 13 багаас тус бүр нэг өрх сонгон нийт 16 ширхэг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-ыг туршилтаар айл өрхүүдэд хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн. Тус төслийг 2026 онд тус сумын 500 өрхөд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Дулаан алдагдлыг бууруулах зорилгоор хуучны орон сууц, сургууль, дотуур байр, цэцэрлэгийг дулаалах ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. 2021 онд 2 орон сууц, 2022 онд 1 орон сууц, төрийн 3 байгууллага, 2023 онд төрийн 7 байгууллага, 2024 онд 5 орон сууц, төрийн 20 байгууллагад их засвар, дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 462 сая төгрөгөөр Богд сумын цэцэрлэг, Баянхонгор сумын 113 дугаар байрны засвар, орон нутгийн төсвийн 521.2 сая төгрөгөөр Хүүхдийн Тэмүжин театрын их засвар дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтарсан А/466/А/290 тоот хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Чойр хотын агаарын чанарын сайжруулах бүсэд мөрдөх журам"-ын 2 дахь хэсэгт иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хүлээх</p>	<p>боловруулан байшин сууцтай өрхийн дэвээр, ханын дулаалгыг тендер шалгаруулалтаар, гэр сууцтай өрхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран чип дулаалгын багцаар тус тус дулаалж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар нийт 2476 гэр болон байшин сууц дулаалаад байна.</p> <p>"Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 04, 05, 06 дугаар тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон нийслэлийн Засаг даргын 2025 оны А/651, А/983 дугаар тушаал, захирамжуудын хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг дулаалж, хийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 3950 өрхийг бүрэн дулаалж, 3976 өрхөд хийн түлшний төхөөрөмжийг суурилуулаад байна. Дулаалга хийснээр хэрэглээ 2 дахин буурч, зардал багасаж байна.</p> <p>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран 2025 онд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийг гэр цэцэрлэгүүд болон 13 багаас тус бүр нэг өрх сонгон нийт 16 ширхэг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-ыг туршилтаар айл өрхүүдэд хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн. Тус төслийг 2026 онд тус сумын 500 өрхөд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Дулаан алдагдлыг бууруулах зорилгоор хуучны орон сууц, сургууль, дотуур байр, цэцэрлэгийг дулаалах ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. 2021 онд 2 орон сууц, 2022 онд 1 орон сууц, төрийн 3 байгууллага, 2023 онд төрийн 7 байгууллага, 2024 онд 5 орон сууц, төрийн 20 байгууллагад их засвар, дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 462 сая төгрөгөөр Богд сумын цэцэрлэг, Баянхонгор сумын 113 дугаар байрны засвар, орон нутгийн төсвийн 521.2 сая төгрөгөөр Хүүхдийн Тэмүжин театрын их засвар дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтарсан А/466/А/290 тоот хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Чойр хотын агаарын чанарын сайжруулах бүсэд мөрдөх журам"-ын 2 дахь хэсэгт иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хүлээх</p>	<p>/2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03/7454 дугаартай албан бичиг/</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /2026 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн 03/1394 дугаартай албан бичгийн хавсралтаар/</p> <p>Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 3/628 дугаартай албан бичиг/</p> <p>Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1334 дугаартай албан бичиг/</p> <p>Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар</p>	Хэрэгжих шатанд
-------	---	---	---	-----------------

	<p>Үүргийг тодорхой тусгасан. Үүнд гэр хорооллын айл өрхүүд болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүд гэр, барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах, түлш болон зуухны стандартын шаардлагыг чанд мөрдөх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагаас өгч буй зөвлөмж, мэдээллийг авч хэрэгжүүлэх, агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлж буй эх үүсвэрийг багасгах, зөв дадал хэвшүүлэх, хог хаягдлыг зориулалтын цэгт ангилан цуглуулах, эрчим хүч хэмнэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2025 оны орон нутгийн төсөвт агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 37.7 сая төгрөг батлагдсан. Үүнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажил зохион байгуулахад 0.7 сая төгрөг, монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" худалдан авах ажил 37 сая төгрөг тус тус батлагдсан.</p> <p>Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ гэж тусгасан.</p> <p>Тус аймгийн Дархан сумын 7, 8 дугаар баг Манхан толгой, Наран толгойн айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг Цагаан зуун ХХК гүйцэтгэж 2020 онд ашиглалтад оруулсан. 2022 оны жилийн эцсээр 28 айл төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. 2023 онд 8 айл шинээр төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийт 36 айл холбогдоод байна. Дархан сумын 5 дугаар багийн гэр хороололд 2019-2021 оны хооронд Бурхан Хясаат ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан 4 ашиглалтын зардал өндөр гарч байгаагаас шалтгаалан айл өрхүүд шугам сүлжээнд холбогдоогүй байна. Мөн багийн нутагт дэвсгэрт байрлах Дулааны төв шугам К27-К35 худгийн Ф377*9мм голчтой 1222хос метр шугамыг Ф530*10мм шугамаар, К35-К39 худгийн Ф325*9мм голчтой 375хос метр шугамыг Ф480*10мм шугамаар, 13ш дулааны төв худаг өргөтгөх ажлыг Одкон холдинг ХХК, 2023 оны 04 сарын 19-ний өдрөөс ажил эхлээд, зураг, төсвийн дагуу шугам хоолойг угсрах ажил хийгдэж байна. ТК29 дүгээр худагаас газар шорооны ажил эхэлсэн. 2024 оны 04 сарын 19-ний өдрөөс эхлэн 2023 оны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж шугам хоолой угсрах ажил хийгдэж дууссан. Нөхөн сэргээлтийн ажил үргэлжилж байна.</p> <p>2022 онд Тосгон чиглэлийн гадна дулааны инженерийн шугам сүлжээний ажлыг /Дулааны шугам ф100мм-ф150мм-ийн хоорондын 1350м урттай шугам/ "Өгөөмөр баян булаг" ХХК улсын төсвийн 0.935 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p>	<p>/2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 05/1157 дугаартай албан бичиг/</p>	<p>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 5/1664 дугаартай албан бичиг/</p>
--	---	---	--

		<p>Дархан сумын 1, 2, 3 дугаар багт байрлах сургууль, цэцэрлэг, эмнэлэг, багийн төвийн байруудыг холбохоор ажлын зураг, төсөв боловсруулагдсан. Шугам угсралтын ажлын зураг төсөв магадлалын албаар 1.134 сая төгрөгөөр баталгаажиж өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд дулаан, хэрэгцээний халуун ус, хүйтэн усны шугамын угсралтыг Дарханы дулааны сүлжээ ТӨХК, бохир усны шугамын Дархан ус суваг ХК гүйцэтгэж төрийн өмчийн сургууль цэцэрлэг, багийн төв, өрхийн эмнэлгүүд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.</p> <p>Европын холбооны санхүүжилттэй Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 5, 8 дугаар багийн 598 өрхийн дулааны шугам сүлжээнд холбох шугамын зураг төслийг хийж гүйцэтгэсэн. Дархан сумын 8 дугаар багийн Манхан толгойн хэсгийн гадна инженерийн шугам сүлжээнд хэрэглэгчийг холбох зураг төслийг боловсруулж, 35 өрхийн техникийн нөхцөлийг гаргуулж, угсралтын шатанд салбар шугамд хамт холбогдох шаардлагатай 33 өрхийн техникийн нөхцөлийг нэмэлтээр гаргуулсан. Мөн Дархан сумын 8 дугаар багийн Наран толгойн хэсэгт, 7 дугаар багийн Алтангадас хэсэгт нийт 75 айл өрх дулааны шугам сүлжээнд холбогдсон. "Ихэр алтан дөл" ХХК-ийн гэр хорооллын айл өрхийн дулааныг найдвартай, нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт багатай, бүрэн шаталтат, нам даралтын зуухнаас нэгдсэн байдлаар хангах төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Дархан сумын 9,10 дугаар багт байрлах 23, 25 дугаар хорооллуудад 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 166 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдоод байна. Дархан сум 8 дугаар баг, Наран толгой хэсэгт 36 айл инженерийн шугам сүлжээнд холбогдсон. 2024 онд Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 5 дугаар багийн Залуучууд, Цагаан нуур, Хүнсчид, Үйлдвэр, 8 дугаар багийн Наран толгойн, Манхан толгой хэсгийн нийт 591 айлын инженерийн шугам сүлжээнд холбох зураг төсөв хийгдсэнээс 179 айл хүсэлтээ гаргаж гэрээгээ байгуулсан. Манхан толгойн хэсэгт 35 айлын техникийн нөхцөл гарсан. Наран толгой хэсэгт 45 айл инженерийн шугам сүлжээнд холбогдсон.</p>	
--	--	--	--

	<p>Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Бүтээлч Хөвсгөлчүүд" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг хамгаалан, амьдрах орчныг сайжруулахыг тэргүүлэх зорилт болгон туслав. Хөвсгөл аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 108 тэрбум төгрөгөөр 47 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Үүнийг салбараар авч үзвэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Боловсролын салбарт 37 хувь; 2. Хот байгуулалт, дэд бүтцийн салбарт 39 хувь; 3. Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт 12 хувь; 4. бусад салбарт 12 хувь байна. <p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах, агаарын бохирдол, тоосжилтыг бууруулж 3000 яндан буулгах зорилтын хүрээнд Хөвсгөл аймагт төвлөрсөн дулааны шугам сүлжээг өргөтгөх ажил үе шаттайгаар амжилттай хэрэгжиж байна.</p>	<p>Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр цахимгаар/</p>	
	<p>Баян-Өлгий аймагт улсын төсвөөс санхүүжилт хуваарилагдаагүй бөгөөд одоогоор ямар нэгэн ажил хэрэгжээгүй байна.</p>	<p>Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 3-02/994 дугаартай албан бичиг/</p>	
	<p>Дорноговь аймгийн хэмжээнд дулааны шугам шинээр татах болон хуучин шугамын засвар, дулаалгын ажлыг 871 сая төгрөгийн санхүүжилтээр 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн. 2025 онд инженерийн шугам сүлжээнд холбогдсон нийт 140 айл өрх, 4 аж ахуйн нэгж байна. 2026 оны 5 дугаар сард Дорноговь аймгийн Сайншанд сумын 6 дугаар багт байрлах "Дулааны Эх үүсвэр-2"-оос Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль хүртэл гадна дулааны шугамын ажлын 908.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгасан байна.</p>	<p>Дорноговь аймгийн Засаг дарга /2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1873 дугаартай албан бичиг/</p>	
	<p>Төсөвт тусгагдаагүй тул үйл ажиллагаа явагдаагүй болно.</p>	<p>Булган аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 3/1978 дугаартай албан бичиг/</p>	
	<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс /СТБЗ/ 2023 онд "Тогтвортой хөгжлийн зорилтуудын /ТХЗ/ санхүүгийн таксономи"-ийг баталж, уг таксономийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл туршилтын журмаар нэвтрүүлэн, хэрэгжилтийн явцад шаардлагатай сайжруулалтыг хийхээр тусгасан. Банкууд болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн</p>		

1.14.	14/агаарын бохирдлыг бууруулах зорилгоор олгож байгаа холбогдох татаасыг дулаалгын бодлогод чиглүүлж, ногоон зээлийн хүүгийн татааст шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, зээлийн хүүг 6 хувиас ихгүйгээр тогтоох;	Холбоо /ТоС холбоо/-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу туршилтын хугацааг 2026 оны 1 дүгээр улирал хүртэл сунгасан бөгөөд Монголбанк нь ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг шинэчлэх чиглэлээр ТоС холбоо, банкууд болон холбогдох яамнуудтай хамтран ажиллаж байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-117 дугаар тушаалаар баталсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын хавсралтад "Монгол Улсын ногоон таксономи"-ийн дагуу тодорхойлсон "Ногоон барилгын зээл"-ийг нэмж, харгалзах активын эрсдэлийн жинг 75 хувиар тогтоох шийдвэрийг гаргасан. Иймд тогтоолын 1 дэх хэсэгт заасан үүрэг даалгаврын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон бусад олон улсын байгууллагууд хамтран Сангийн яамны манлайллаар Ажлын хэсэг байгуулагдан "Монгол Улсын ногоон таксономи"-ийг "ТХЗ-ын санхүүжилтийн таксономи" болгон дахин шинэчилж байна. Энэ шинэчлэлээр "BestGER" стандартыг уг таксономийн ногоон барилгын шалгуурт оруулсан тохиолдолд дээр дурдсан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-117 дугаар тушаалд хамрагдах бүрэн боломжтой юм.	Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд
1.15.	15/монгол гэрийн дулаалгын нийт зардлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;	Нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд Баянгол, Чингэлтэй дүүргийн нийт 1361 өрхийн гэр сууцыг дулаалах ажлыг нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан "Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээ"-ний зардлаас 2,041,500,000 төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэж байна. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 2025 оны төсөвт 100 сая төгрөг тусгасан. Уг төсвөөр монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төхөөрөмжийг худалдан авах тендерийг зарлаад байна. Мөн 2026 онд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх саналын жагсаалтад монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төсөлд тусган иргэдээс санал авч байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран 2019-2022 онд гэр хорооллын зорилтот бүлгийн 602 айлыг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төсөлд хамруулсан. 2025 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100 сая төгрөгийн санхүүжилт, иргэдийн оролцоотойгоор 50 айл өрхийг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-аар хангах ажлыг зохион байгуулсан. Дундговь аймаг нь 2024 онд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-аас 200 ширхгийг захиалсан. Үүнээс 180 ширхгийг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03/7454 дугаартай албан бичиг/ Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 3/628 дугаартай албан бичиг/ Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1334 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд

	<p>2024 онд айл өрхүүдэд бүрэн олгосон бөгөөд нийлүүлэгдээгүй үлдсэн 20 ширхэг багцыг 2025 онд төлбөрөө төлсөн хэрэглэгчдэд хүргэн ажилласан. 2026 онд аймгийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дараах 2 ажлыг төвлөсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дулааны цахилгаан станц барих төсөл; - Хуучин барилга, байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах. <p>Агаарын чанарыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн "Уур амьсгалын өөрчлөлт ба Цэвэр агаар" хөтөлбөрийн хүрээнд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр айл өрхүүд энгийн галлагаатай зуух, пийшинг халж аюулгүй, ухаалаг цахилгаан халаагуур болон гэр дулаалгын багц үйлчилгээг авсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2023 онд НҮБ-ийн 100 хувийн санхүүжилтээр 160 сая төгрөгөөр 50 өрхөд үнэгүй багц олгосон; - 2023 онд орон нутгийн 50 сая төгрөгийн санхүүжилтээр иргэдийн 50 хувийн татаасаар 34 өрхөд багц олгосон; - 2024 онд орон нутгийн 1,3 тэрбум төгрөгийн төсвөөр 867 өрхийг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-аар багцаар хангах төсвийг баталж, 467 өрхөд багц олгосон. Энэхүү ажлын хүрээнд Баруун-Урт сумын гэр хорооллын 6 дэд станцыг орон нутгийн төсвийн 300 сая төгрөгөөр өргөтгөсөн; - 2025 онд 12 суманд тус бүр 20 айл, нийт 240 айлыг монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-аар хангаад байна. <p>Говьсүмбэр аймгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" худалдан авах ажлыг 37 сая.төгрөгөөр баталж, худалдан авах ажиллагааг 5 удаа зарласан боловч шаардлага хангасан тендерт оролцож ороогүй тул хэмнэлтийн хүрээнд уг төсөв татагдсан.</p> <p>Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар багийн 6, 11 дүгээр багийн 10, 12, 13 дугаар багийн 13, 24 дүгээр байрны дулаалга, гадна фасад засварын ажлыг УТХО-213,6 сая.төгрөгөөр "Цахир түмэн Алтай" ХХК гүйцэтгэж байна. /5 байр/. Дархан сумын нийтийн зориулалттай орон сууцны 170 байрны</p>	<p>Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/1575 дугаартай албан бичиг/</p> <p>Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 04/1337 дугаартай албан бичиг/</p> <p>Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 05/1157 дугаартай албан бичиг/</p>
--	--	--

	<p>цоколд хаалт хийх ажлыг 204 сая.төгрөгөөр гүйцэтгэсэн. 2021-2022 онд 19 байр, 2023 онд 5 байранд тус тус хийсэн.</p> <p>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй нүүрсгүй шийдэл монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийн талаарх мэдээллийг аймгийн Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн Ажлын хэсэгт танилцуулсан. Гэр мэдээллийн төвийг үргэлжлүүлэн ажиллуулж байна. Төслийн хүрээнд халаалтын багц авсан Дархан сумын 5, 6, 7 дугаар багийн нийт 12 айл өрх байна.</p> <p>"Дулаан шийдэл II" төсөл "Амины орон сууцыг дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих ногоог зээлийн эргэлтийн судалгаа" хийж холбогдох тайлан ирүүлсэн. Оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж гэр хорооллын байшин сууцтай айл өрхүүдийг дулаалах боломж, шийдлүүдийг хэлэлцсэн. Дулаалгын бригад, Дулаалгын зөвлөх бэлтгэх 2 багц сургалтыг хамтран зохион байгуулж барилгын салбарын 27 бичил жижиг бизнес эрхлэгчийг чадавжуулав. Сургалтаар барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ-камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт, дулааны камертай хэмжилтийн онлайн сургалт, дулаалгын зөвлөхүүдэд зориулсан сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн дулаалгын "Хялбар шийдэл" аяныг хамтран зохион байгуулсан. Айл өрхүүдийн дулаан алдагдлыг хэмжих дулааны камерыг түр хэрэглэх гэрээгээр хүлээлгэн авав. Өвлийн хэмжилтийн үйл ажиллагааг зохион байгуулж айл өрхүүдийн дулаан алдагдал, эрчим хүчний хэмнэлтийг тодорхойлсон.</p> <p>Дархан сумын 15 дугаар багийн дулаан хангамжийн шугамыг 31 дүгээр хорооллын дулаан хангамжтай холбох тойрог схемд оруулах ажлыг орон нутгийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 5/1664 дугаартай албан бичиг/</p>
<p>2025 оны төсөвт суудсан төсөв байхгүй бөгөөд 2026 оны аймгийн төсөвт санал оруулан төсөв хэлэлцэх ажил үргэлжилж байна.</p>	<p>Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 09/2357 дугаартай албан бичиг/</p>	<p>Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 09/2357 дугаартай албан бичиг/</p>
<p>Монгол гэрийн дулаан алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр одоогоор аймгийн хэмжээнд хэрэгжээгүй байна.</p>		<p>Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар</p>

		<p>Монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-ыг гэр хорооллын айл өрхөд хөнгөлөлттэй үнээр олгохоор 2025 онд орон нутгийн төсөвт 130 сая төгрөг батлуулж гэр хорооллын 63 өрхөд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-ыг олгон бохирдуулагч эх үүсвэрийн тоог 63-аар буулгасан. 2021-2025 онд Баян-Өндөр сумын нийт 245 өрхөд монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц"-ыг хөнгөлөлттэй үнээр олгосон.</p> <p>Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, ахуйн хүрээнд бага насны хүүхдийн осол гэмтэл түлэгдэлтийг бууруулах зорилгоор Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийг хэрэгжүүлж байна. Тус төслөөр 2020-2025 онд Даланзадгад-1025, Ханбогд-100, Цогтцэций-100 өрх, нийт 1225 айл өрхийг хамруулсан. Дээрх төслийн зардалд орон нутгийн төсвөөс 2.5 тэрбум, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас 380.8 сая төгрөг, нийт 2,9 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>Монгол гэрийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий аймагт санхүүжилт хуваарилагдаагүй болно. Баян-Өлгий аймагт монгол гэрт амьдардаг айл өрхийн тоо маш бага, бараг байхгүйтэй холбоотойгоор дээрх чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага үүсээгүй байна.</p> <p>Монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төслийг Дорноговь аймгийн хэмжээнд сурталчлах арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Төслийн хүрээнд Сайншанд сумын 10 айл, өрхөд СНИР багцыг хүлээлгэн өгсөн. Аймгийн хэмжээнд 4768 айл өрхийн хэрэгцээнд ердийн зуух ашиглаж байна. 2025 онд нийт 115 айл өрх ердийн зуух ашиглахаа больсон. 2024 онтой харьцуулахад агаар орчныг бохирдуулагч эх үүсвэрүүд 2.5 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Нийт төсөв 30 сая төгрөг.</p> <p>Төсөвт тусгагдаагүй тул үйл ажиллагаа явагдаагүй болно.</p>	<p>/2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 06/1118 дугаартай албан бичиг/</p> <p>Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр /</p> <p>Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр цахимаар/</p> <p>Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 3-02/994 дугаартай албан бичиг/</p> <p>Дорноговь аймгийн Засаг дарга /2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1873 дугаартай албан бичиг/</p> <p>Булган аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3/1978 дугаартай албан бичиг/</p>
--	--	--	--

		<p>Монгол гэрт зориулсан дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "Чип багц" төсөл төслийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр 2025 онд 7 өрх айлын дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн болно.</p> <p>Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ногоон хөгжлийн бодлого-2030" бодлогын баримт бичгийн 1.3.6.7-1.3.6.9 дэх заалтуудын хүрээнд банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах, ногоон хөрөнгө оруулалтын эх үүсвэр, санхүүжилтийн боломжийг судлах, мөн Орон нутгийн хөгжлийн сангаас ногоон зээл, санхүүжилт олгох боломжийг эрэлхийлэх чиглэлээр холбогдох судалгаа, ажлуудыг тусган хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсвөөс 150 сая төгрөг төсөвлөсөн.</p>	<p>Төв аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02/1986 дугаартай албан бичиг/</p>	
1.16	<p>16/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан айл өрхүүд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж, орлого олох</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3.3.12-т "10000 нарны дээвэр" хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу эрчим хүчний нэгдсэн системд сэргээгдэх эрчим хүчний оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд өндөр ач холбогдол өгөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Азийн хөгжлийн банктай хамтран "Coal to Solar" буюу "Нүүрснээс нар руу" төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн хүрээнд 4 кВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан үүсгүүр, цэнэг хураагуур, дулааны насос зэрэг шинэ технологийг Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй гэр хорооллын 400 орчим айл өрхөд суурилуулахаар төслийн агуулгыг бэлтгэн ажиллаж байна. Тус нарны систем нь хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний тодорхой хувийг хангаж, оргил ачааллыг бууруулан, гэр хорооллын айл өрхийн хатуу түлшний хэрэглээг багасгана. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2025 онд Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотуудад нийт 68 айлын бага оврын нарны эх үүсвэрийг түгээх сүлжээнд холбон ашиглалтад оруулсан, 2026 онд 100 айлын бага оврын нарны эх үүсвэрийг түгээх сүлжээнд холбох төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд нийт 3000 айлын бага оврын нарны эх үүсвэрийг түгээх сүлжээнд холбох зорилт тавин санхүүжилтийн механизмгүй тодорхойлохоор ажиллаж байна. Эрчим хүчний яамны зүгээс Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.5-т дахь заалтын хүрээнд Эрчим хүчний сайдын 2020 оны 08 дугаар сарын</p>	<p>Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар /2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр цахимаар/</p>	<p>Эрчим хүчний яам /2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ө/3560 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>

	<p>бололцоог нээж байгаа "10000 нарны дээвэр" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;</p>	<p>14-ний өдрийн 159 дүгээр тушаалаар "Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам"-ыг баталж айл өрх, аж ахуй нэгжүүд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр ашиглан үйлдвэрлэсэн эрчим хүчийг худалдан авах боломжийг бүрдүүлсэн. Эрчим хүчний зохицуулах хороо 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 28 дугаар тогтоолоор "Төв, Өмнөд, Зүүн, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний тариф"-ыг өдрийн 06:00-17:00 цагийн хооронд 285 төгрөг/кВт.цаг, оройн 17:00-22:00 цагийн хооронд 300 төгрөг/кВт.цаг байхаар шинэчлэн тогтоосон. Батлагдсан журмын хүрээнд улсын хэмжээнд 2020 оны 08 дугаар сараас 2025 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 116 хэрэглэгчийн 2,142.06 кВт хүчин чадал бүхий нарны үүсгүүр болон 1,565.9 кВт.цаг багтаамжтай батарей хуримтлуурыг түгээх сүлжээнд холбон ашиглалтад оруулсан. 2025 оны 01 дүгээр сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд 39 хэрэглэгчийн 822.58 кВт хүчин чадал бүхий нарны үүсгүүр түгээх сүлжээнд холбогдсон. Иймд "10000 нарны дээвэр" хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд техникийн боломжийг тодорхойлох судалгаа хийгдэж байна.</p>	
1.17.	<p>17/эрчим хүчний хэмнэлт, ногоон барилгын хөгжлийг дэмжихтэй уялдуулан холбогдох чиглэлийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургуулийн хичээлийн хөтөлбөрт ногоон барилга, тогтвортой хөгжлийн агуулгыг тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>"Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх" /Эн Ди Си/ төслийн санхүүжилтээр "Агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарал багатай хот байгуулалт, барилга байгууламжийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр" боловсруулах Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй 2022 оны 12 дугаар сард гэрээ байгуулсан. Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарал, түүнийг бууруулах арга хэмжээний талаар салбарын мэргэжилтэн бэлтгэх "Хүлэмжийн хий бага ялгаралтай хот төлөвлөлт ба барилга" ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг тус яамны захиралгаар боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр Шинжлэх ухаан, техникийн их сургуультай хамтран хэрэгжүүлэх болон Хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.</p>	<p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p> <p>Хэрэгжих шатанд</p>
2.	<p>Ногоон зээлийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд үүрэг болгосугай:</p>	<p>Сангийн яамны төрийн бичгийн даргын 2025 оны А/191 дүгээр тушаалаар "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи баримт бичгийг шинэчлэх" чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус Ажлын хэсэг нь холбогдох судалгаа, шинжилгээнд үндэслэн ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний ангилал, шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэхээр ажиллаж байна.</p>	<p>Сангийн яам /2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02/10440 дугаартай албан бичиг/</p>

2.1.	жишигт нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, ногоон санхүүжилтийн тайлагнал, хяналт шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгон ил тод байдлыг сайжруулах;	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс /СТБЗ/ 2023 онд "Тогтвортой хөгжлийн зорилтуудын /ТХЗ/ санхүүгийн таксономи"-ийг баталж, уг таксономийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл туршилтаар журмаар нэвтрүүлэн, хэрэгжилтийн явцад шаардлагатай сайжруулалтыг хийхээр тусгасан. Банкнууд болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо /ТоС холбоо/-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу туршилтын хугацааг 2026 оны 1 дүгээр улирал хүртэл сунгасан бөгөөд Монголбанк нь ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг шинэчлэх чиглэлээр ТоС холбоо, банкнууд болон холбогдох яамнуудтай хамтран ажиллаж байна.	Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/	Хэрэгжих шатанд
2.2.	2/арилжааны банкуудын ногоон зээлийн тайлан гаргах давтамж, бүрдүүлэлт, мэдээллийн чанар, шалгуурыг шинэчлэн сайжруулах арга хэмжээг авах;	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А-198 дугаар "Банкны ногоон зээлийн тайлангийн маягт батлах тухай" тушаалын дагуу Монголбанк нь банкуудын ногоон зээлийн тайланг улирал тутам нэгтгэн боловсруулж, олон нийтэд тогтмол танилцуулж байна. Түүнчлэн, 2022 оноос эхлэн банкуудын ногоон зээлийн тайлангийн гол үзүүлэлтүүдийг хүйсээр ангилан жил бүр оны эцсийн байдлаар нэгтгэн нийтэлж байна. Банкнүүдаас олгосон ногоон зээл 2025 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 836.4 тэрбум төгрөг буюу 70,8 хувиар өсөж, 2,017.3 тэрбум төгрөг хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 4.7 хувийг эзэлж байна. Банкууд 2024 оны эцсийн байдлаар 7,270 зээлдэгчийн 1,352.8 тэрбум төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй байснаас 40,7 хувь буюу 551.2 тэрбум төгрөг нь эмэгтэй зээлдэгчдэд олгогджээ.	Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/	Хэрэгжсэн
2.3.	3/ногоон зээлийн хүүгийн татаасын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад валютаар хийдэх своп хэлцэлд бодлогын дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах;	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 30-ны А-162 дугаар тушаалаар "Урт хугацаат своп хэлцэл"-ийн журмыг шинэчлэн баталсан. Тус журамд банк ногоон таксономигийн ангилалд багтсан эх үүсвэрээр своп хэлцэл байгуулах тохиолдолд свопын зардлыг 0.5 хувиар хөнгөлөх тухай заалтыг оруулж, ногоон санхүүжилтийг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн. Түүнчлэн, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-83 дугаар тушаалаар тус хөнгөлөлтийн хувийг 1 хувь болгон нэмэгдүүлсэн. Ногоон санхүүжилтийг дэмжих зохицуулалтын хүрээнд Монголбанк 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 704.3 сая ам.доллартой тэмцэх урт хугацаат своп хэлцэл байгуулаад байна.	Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/	Хэрэгжсэн
2.4.	4/ногоон барилгын зээлийн эрсдэлийн жинг бууруулах бодлогыг ногоон барилгын шалгуур /BestGER/-т	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-117 дугаар тушаалаар "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын хавсралтад "Монгол Улсын ногоон таксономи"-ийн дагуу тодорхойлсон "Ногоон барилгын зээл"-ийг нэмж, харгалзах активын эрсдэлийн жинг 75 хувиар тогтоох шийдвэрийг гаргасан. Иймд тогтоолын 1-д заасан үүрэг даалгаврын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон	Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн	Хэрэгжих шатанд

	<p>уялдуулан цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлж, шаардлагатай зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох;</p>	<p>бусад олон улсын байгууллагууд хамтран Сангийн яамны манлайллаар Ажлын хэсэг байгуулагдан "Монгол Улсын ногоон таксономи"-ийг "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи" болгон дахин шинэчилж байна. Энэ шинэчлэлээр "BestGER" стандартыг уг таксономийн ногоон барилгын шалгуурт оруулсан тохиолдолд дээр дурдсан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-117 дугаар тушаалд хамрагдах бүрэн боломжтой юм.</p>	<p>A/12/015 дугаартай албан бичиг/</p>	
<p>2.5.</p>	<p>5/Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд ногоон барилгын шалгуур /BestGER/ үнэлгээний үзүүлэлт, эрчим хүчний хэмнэлтийн бодлоготой уялдуулан, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд давуу байдал олгох зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлэх.</p>	<p>Ипотекийн зээлийн санхүүжилтэд амины орон сууцыг хамруулах үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор Монголбанкт хамтран ажиллаж, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын 1.2.13 дахь заалтад 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулж, "Амины орон сууц" гэх нэр томъёоны ойлголтыг нарийвчлан тодорхойлсон. Амины орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч арилжааны банкуудад журмын өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг үнэлэх үнэлгээний систем /BestGER/, тавигдах шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх уулзалтыг Монголбанкт хамтран 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Мөн Амины орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг ямар аргачлалаар олгох талаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр "Монголын банкны холбоо" ГҮТББ-ийн Зээлийн эрсдэлийн хороогоор хэлэлцүүлж, Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, Ногоон барилгын аудитор бэлтгэсний дараа дахин хэлэлцэхээр тохиролцсон. Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Монголбанк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот төлөвлөлт хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, "Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв" УТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудыг хамруулсан "Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх" нь сэдэвт уулзалтад 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр оролцсон. Тус уулзалтаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар баталдсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулахаар тохирсон. Журамд өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулаад байна. Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Ипотекийн 6 хувийн зээлийн журамд Ногоон барилгын үнэлгээний "BestGER" системээр үнэлэн олгосон гэрчилгээг үндэслэн зээл олгох өөрчлөлт оруулах боломжтой талаар</p>	<p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/4298 дугаартай албан бичиг/</p>	<p>Хэрэгжих шатанд</p>

		<p>Монгол банкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал, холболдох мэргэжилтнүүд болон Монголын Ногоон барилгын хүрээлэнгийн төлөөлөлтэй хамт 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Монголбанк дээр уулзалт хийсэн. Хамтыг ажиллагааг өргөжүүлж, 2025 онд баггаан журмын өөрчлөлтийг хийж, иргэдэд Ногоон зээлийг хувийн орон сууцанд олгож эхлүүлэхээр тохиролцсон.</p> <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас "BestGER" үнэлгээний стандартыг баталж байгаатай холбоотойгоор бүх төрлийн амины орон сууцыг хөтөлбөрийн зээлд хамруулах зорилгоор "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-д Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-235 дугаар тушаалаар амины орон сууцны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлт орсноор амины орон сууцны бүсэд баригдсан, эрчим хүчний хэмнэлттэй, ханаараа нийлсэн болон эгнээгээр баригдсан бүх төрлийн амины орон сууц худалдан авах иргэд хөтөлбөрийн зээлд хамрагдах боломжтой болсон.</p>	<p>Монголбанк /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12/015 дугаартай албан бичиг/</p>	
--	--	---	--	--

---oOo---